



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/512

Улаанбаатар хот

**Энгийн болон тусгай зөвшөөрөл олгох,  
сунгах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3, 5.2, 5.3, 8.1 8.2 дугаар зүйл, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйл, 16 дугаар зүйл, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хязгаар шинэчлэн тогтоох тухай” А/847 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Энгийн болон тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх үүрэг бүхий” ажлын хэсгийн 21 дүгээр хурлаар дэмжигдсэн, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгох 3 аж ахуйн нэгжийн жагсаалтыг нэгдүгээр, үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох 2 аж ахуйн нэгжийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Л.Саруултуяа)-т, хяналт тавьж ажиллахыг Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар (хурандаа Д.Дашням)-т, Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс (Г.Сүрэнтамжид)-т, хороодын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг дүүргийн Менежер (Ц.Эрдэнэбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ч.БАЗАРЗАЯА

1725011412

Хан-Уул дүүргийн Засаг даргын  
2025 оны 10 дугаар сарын  
24-ний өдрийн 41513 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Аж ахуйн нэгжийн нэр | Регистрийн дугаар | Захирлын нэр | Оноосон нэр    | Үйлчилгээний ангилал | Зөвшөөрлийн төрөл | Хаяг, байршил                                                                                |
|-----|----------------------|-------------------|--------------|----------------|----------------------|-------------------|----------------------------------------------------------------------------------------------|
| 1   |                      | 3                 | 4            | 5              | 6                    | 7                 | 8                                                                                            |
| 1   | Хатан үйлс өгөөж ХХК | 7184489           | А.Эрдэнэбат  | " "            | Хүнсний дэлгүүр      | 06:00-00:00       | 19 дүгээр хороо Үйлдвэр (17042), ЧӨЧ гудамж 77/3 байр 102 тоот                               |
| 2   | Эр хасар ХХК         | 6584764           | Э.Ганпүрэв   | Хонгор         | Минимаркет           | 06:00-00:00       | 21 дүгээр хороо Буянт ухаа хороолол (17121), Архивчдын зам гудамж 435 байр 1 давхар 101 тоот |
| 3   | Билэг оюу өгөөж ХХК  | 7190577           | П.Банзрагч   | Элемент маркет | Минимаркет           | 06:00-00:00       | 23 дугаар хороо Арцатын ам (17100), Нүхтийн зам гудамж 730 байр А2 тоот                      |



Хан-Уул дүүргийн Засаг даргын  
2025 оны 04-11 өдрийн захирамжийн 2 дугаар хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Аж ахуйн нэгжийн нэр | Регистрийн дугаар | Захирлын нэр | Оноосон нэр | Үйлчилгээний ангилал | Зөвшөөрлийн төрөл          | Хаяг, байршил                                                                |
|-----|----------------------|-------------------|--------------|-------------|----------------------|----------------------------|------------------------------------------------------------------------------|
| 1   | 2                    | 3                 | 4            | 5           | 6                    | 7                          | 8                                                                            |
| 1   | Ти энд Ти блэк       | 6318282           | Б.Баясгалан  | ЗҮ корнер   | Ресторан             | 11:00-22:00<br>14:00-04:00 | 18 дугаар хороо Хүннү<br>2222 Их монгол улс<br>гудамж 101-118 байр 8<br>тоот |
| 2   | Фүжи скай апекс ХХК  | 7146505           | Л.Нармандах  | Лайм        | Баар/тайчих клуб     | 14:00-04:00                | 15 дугаар хороо<br>Стадион оргил<br>Махатма ганди гудамж<br>64 тоот          |